



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/76

Мандалговь

Сургалт явуулах тухай


Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 33 дугаар зүйл, “Дайчилгааны тухай хууль”-ийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 230 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/01, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 1.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн штабын “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу ДБНБ-ний I зэргийн бэлтгэл үүрэгтэн 20 хүний сургалтыг 14 хоногийн хугацаатайгаар Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн материаллаг баазыг түшиглэн 2019 оны 3 дугаар сарын 25-наас 4 дүгээр сарын 7-ныг дуустал явуулсугай.

Хоёр. Батлан хамгаалах яамнаас төсөвлөсөн сургалтын зардал 3.671.000 (гурван сая зургаан зуун далан нэгэн мянга) төгрөгийг гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Дээрх ДБНБ-ний нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн байлдагч, түрүүчийн сургалтыг төлөвлөгдсөн хугацаанд чанартай, осол авааргүй явуулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010200

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын
03-ны өдрийн 176 тоот захирамжийн хавсралт



Хамрагдах хүний тоо	Хугацаа	Байр хоолны зардал	Тээврийн буюу унааны зардал	Сургалтын зардал	Бусад зардал	Нийт зардал
20	14	2.172.800	200.000	1.198.200	100.000	3.671.000